

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7
2.8.2 Авлага.....	8
2.8.3 Урьдчилгаа	9
2.8.4 Бараа материал	10
2.8.5 Үндсэн хөрөнгө.....	10
2.8.6 Өр төлбөр.....	11
2.8.7 Засгийн газрын хувь оролцоо.....	12
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	14
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	15
2.12. Шилэн дансны мэдээлэл	16
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	16
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	16
3. Менежментийн захидал	18
3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал	18
3.2 Дотоод хяналттай холбоотой асуудал.....	18
3.3. Үндсэн хөрөнгийн хөдлөлтэй холбоотой асуудал	19
3.4 Орлогын төлөвлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал.....	19
3.5. Төсвийн зарцуулалт, бүртгэлтэй холбоотой асуудал	20
3.6 Дотоод хяналттай холбоотой асуудал.....	21
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
4.1. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	22
4.2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	23
4.3. Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	24
4.4. Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	25
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	26
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	29
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	31

Товчилсон үгийн жагсаалт

АЕГ	Архивын ерөнхий газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
НУБГ	Нийслэлийн улсын бүртгэлийн газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УБГ	Улсын бүртгэлийн газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Ц.НЯМДОРЖ ТАНАА

2020.04.24 № 1443
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, НББОУС, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж мөрдөх, давсан орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, хөрөнгийн хөдөлгөөн, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөс 2020 оны 4 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул гүйцэтгэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 1-1/1407 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэн, чанарын хяналтыг хэрэгжүүлж холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Засгийн газрын 2019 оны 11 дүгээр тогтоолоор тус яамны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан байна.

Уг тогтоолд Хууль зүй, дотоод хэргийн яамны эрхэм зорилгыг “Монгол Улсад шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлж, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны 5 тэргүүлэх чиглэлийг тодорхойлжээ.

Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх, бизнесийн эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн бодлого, хууль сахиулах стратеги, бодлого, төлөвлөлтийг оновчтой тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр хангах замаар сайд, Засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, удирдлагын зохистой хэлбэр төлөвшүүлэх;
- удирдлагын шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар хууль сахиулах салбарын удирдлагын манлайллыг хангах, иргэн, байгууллагад үзүүлэх хууль зүйн үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх;
- хүний нөөцийн удирдлагын шилдэг арга барилыг хэрэгжүүлэх, хууль зүйн боловсрол, эрх зүйн сургалтын бодлогыг тодорхойлон төлөвшүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар оновчтой, чадварлаг бүтцийг хөгжүүлэх, сайдын эрхлэх ажлын хүрээний үйл ажиллагаанд Засгийн газраас төсөвлөсөн хөрөнгө, нөөцийг зохистойгоор хуваарилан зохицуулах;
- олон улсын болон гадаад улс орнуудын ижил төрлийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, олон улсын конвенцид нэгдэн орох, Монгол Улсаас бусад улс, орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ байгуулж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах;
- нээлттэй, ил тод, шуурхай, чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх.

Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгддөг хууль, дүрэм журмуудаас төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйл “Гэрээ шууд байгуулах арга”-д “34.1.11.энэ хуулийн 10¹.2-т заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтад орсон бараа, бүтээгдэхүүнийг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1-д заасан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч үйлдвэрлэсэн бол”,
- мөн хуулийн 10 дугаар зүйл “Тендерт оролцогчдод давуу эрх олгох”-д “10¹-д Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах” гэсэн заалтууд тус тус нэмэгдсэн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, салбарын онцлог бүртгэлийг нэгдсэн байдлаар бүртгэж, тайлагнахгүй байх зэрэг үр дагавартай байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2019 онд орон нутаг дахь харьяа 11 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр тухай бүр зөвлөмж чиглэл өгч, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018, 2019 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс тооцсон.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 924,151.3 сая төгрөгийн 2 хувь буюу 18,483.0 сая төгрөгөөр тооцож батлуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь болон хувь хэмжээнд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 1,009,801.4 сая төгрөгөөс 2 хувиар тооцож 20,196.0 сая төгрөгөөр тогтоолоо.

2.8. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 34,296.8 сая төгрөг болж, 15,918.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	67.4	75.4	8.0
Банканд байгаа бэлэн мөнгө	18,310.8	34,211.3	15,900.5
Замд яваа мөнгөн хөрөнгө	44.6	9.6	(35.0)
Дүн	18,422.8	34,296.3	15,873.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	12,334.6	27,896.6	15,561.5
Төсөл/ сан	3,729.9		(3,729.9)
ТӨҮГ	2,358.3	6,400.2	4,041.8
Дүн	18,422.8	34,296.3	15,873.5

Эх сурвалж: ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс арилжааны банканд 22,192.3 сая төгрөг, гадаад валютын дансанд 170.1 сая төгрөг, Төрийн сангийн дансанд 11,849.0 сая төгрөг байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Нийслэлийн улсын бүртгэлийн газрын үйлчилгээний 9.6 сая төгрөгийн орлого бүртгэлтэй байна.

Төсөвт байгууллагуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 48.6 хувийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн төлбөрийн 13,548.7 сая төгрөг, 26.4 хувийг ЦЕГ-ын Мөрдөн байцаах газрын барьцаа хөрөнгийн тусгай дансны 7,364.4 сая төгрөг, 8.7 хувийг ШШГЕГ-ын арилжааны банкин дахь 2,424.7 сая төгрөг, 4.9 хувийг Банк хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах албаны 1,365.3 сая төгрөг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн /Нийслэлийн УБГ 59.6 сая, УБЕГ 21.1 сая, Говь сүмбэр аймгийн УБГ 2.2 сая, Төв аймгийн УБГ 13.7 сая, Шүүхийн шинжилгээний хүрээлэн 14.0 сая, ГИХГ-ын Зүүн бүс дэх газар 26.9 сая, АЕГ 6.1 сая/,
- Ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан ажилтнуудад нөхөн олговор олгосон /УБЕГ 53.4 сая/,
- Гэрээгээр хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж гэрээ дүгнээгүй, хүлээн авсан акт үйлдээгүй /ГИХГ-ын Дорноговь дахь газар 1.5 сая, Дотоод хэргийн их сургууль 920.0 сая, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн 42.6 сая, Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн аппарат 167.5 сая/,
- Тээвэр шатахууны зардлыг хэтрүүлэн зарцуулсан, илүү худалдан авалт хийсэн, Хот дотор ажил үйлчилгээнд хөдөлгүүрийн 2500 см3-ээс дээш цилиндрийн багтаамжтай автомашин хэрэглэсэн, суудлын автомашин унах эрхгүй албан тушаалтан автомашин хэрэглэн шатахууны зардал гаргасан /Хэнтий аймгийн УБХ 0.6 сая, Булган аймгийн УБХ 1.2 сая, Дархан аймгийн УБХ 0.1 сая, ГИХГ-ын төв аппарат 6.2 сая, ГИХГ-ын Зүүн бүс дэх газар 13.7 сая/,
- Тэтгэвэрт гарсан хүнийг үндсэн ажилтнаар үр дүнгийн гэрээ байгуулан ажиллуулж зэрэг дэв, удаан жилийн нэмэгдэл олгосон /УБЕГ 7.6 сая, ГИХГ-ын төв аппарат 8.4 сая/,
- Ахмадын санд цалингийн зардлаас шилжүүлсэн /ГИХГ-ын төв аппарат 46.0 сая/,
- Төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан /УБЕГ 35.9 сая/.

2.8.2 Авлага

Авлагын эцсийн үлдэгдэл 86,652.9 сая төгрөг болж өмнөх оноос 5,678.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	60.4	39.9	(20.5)
Төлбөртэй үйлчилгээний авлага	132.9	54.3	(78.7)
Татаас, санхүүжилтийн авлага	1,890.6	7,067.5	5,176.9
Дансны авлага /ТӨҮГ/	1,510.0	1,961.6	451.6
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	11.8	36.0	24.3
Байгууллагаас авах авлага	29,745.9	30,268.4	522.5
Хувь хүмүүсээс авах авлага	744.5	577.4	(167.1)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон /Банк хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын алба/	46,877.9	46,647.8	(230.1)
Дүн	80,974.0	86,652.9	5,678.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	79,446.6	77,422.0	(2,024.6)
Төсөл/ сан		7,065.1	7,065.1
ТӨҮГ	1,527.4	2,165.8	638.4
Дүн	80,974.0	86,652.9	5,678.9

Эх сурвалж: ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэл өссөн нь Гэмт хэргээс хамгаалах нөхөн төлбөр олгох сангийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн, татаас санхүүжилтийн авлага үүсгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Авлагын үлдэгдэлд 1-ээс дээш жил болсон 63 байгууллагад үүссэн 512.8 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- 2017-2018 онд үүссэн 29 байгууллагатай холбоотой 150.2 сая төгрөгийн,
- 2010-2016 онд үүссэн 24 байгууллагатай холбоотой 294.3 сая төгрөгийн,
- 2003-2009 онд үүссэн 9 байгууллагатай холбоотой 67.5 сая төгрөгийн,
- 1998 онд үүссэн нэг байгууллагатай холбоотой 0.8 сая төгрөгийн авлага байна.

Дээрх авлагыг барагдуулахгүй он дамжиж байгаа нь насжилт ихтэй, найдваргүй авлага үүсэх, төсвийн хөрөнгө үрэгдэх зэрэг үр дагавартай байна.

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 9,463.9 сая байсан бол эцсийн үлдэгдэл 5,715.1 сая төгрөг болж, үлдэгдэл 3,748.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар	75.7	74.1	(1.6)
Урьдчилж гарсан зардал	8,228.0	4,079.6	(4,148.4)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,061.3	1,111.1	49.8
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	94.7	447.0	352.3
Цалингийн урьдчилгаа	4.2	3.3	(0.9)
Томилолтын урьдчилгаа	0.1	0.1	(0.0)
Дүн	9,463.9	5,715.1	(3,748.8)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	3,417.4	5,547.8	2,110.4
ТӨҮГ	6,046.5	167.3	-5,879.2
Дүн	9,463.9	5,715.1	(3,748.8)

Эх сурвалж: ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдийн 60.7 хувийг ЦЕГ-ын 3,471.2 сая төгрөгийн, 27.6 хувийг ШШГЕГ-ын 1,756.0 сая төгрөгийн үлдэгдэл эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Гэрээт ажлын санхүүжилтийг урьдчилан олгосныг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн /ХЗДХЯ 122.0 сая төгрөг/

2.8.4 Бараа материал

Бараа материалын эцсийн үлдэгдэл 107,177.8 сая төгрөг болж, 192.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	20,646.6	22,650.4	2,003.9
Эм боох материал	2,106.8	1,883.1	(223.7)
Дуусаагүй үйлдвэрлэл	7,243.3	5,148.0	(2,095.3)
Бэлэн бүтээгдэхүүн	24,131.4	20,121.3	(4,010.0)
Бичиг хэргийн материал	2,537.8	2,450.3	(87.5)
Аж ахуйн материал	8,555.3	8,289.1	(266.2)
Сэлбэг хэрэгсэл	1,980.6	1,883.2	(97.4)
Түлш, шатах тослох материал	2,066.5	1,688.2	(378.2)
Барилгын засварын материал	1,605.7	1,523.8	(81.9)
Хүнсний материал	4,901.6	4,718.9	(182.7)
Бусад хангамжийн материал	20,712.8	25,586.3	4,873.5
Мал амьтад	9,351.3	10,319.0	967.7
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	276.4	172.5	(103.9)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	869.5	743.4	(126.1)
Дүн	106,985.7	107,177.8	192.1

Эх сурвалж: ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт

- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн /УБЕГ 30.7 сая/,
- Шатахууны заавал байх нөөцийн норм, нормативыг тогтоогоогүй, шатахууны нөөц үүсгэсэн /ЦЕГ 417.6 сая, АЕГ 17.1 сая/.

2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 887,126.5 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 930,091.1 сая төгрөг болж 42,964.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Авто-тээврийн хэрэгсэл	77,835.1	65,442.2	(12,392.9)
Барилга, байгууламж, орон сууц	431,062.6	472,713.3	41,650.7
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	15,473.3	15,252.1	(221.2)
Дуусаагүй барилга, байгууламж	3,329.3	6,554.3	3,225.0
Зам, гүүрийн байгууламж	143.0	143.0	-
Машин тоног төхөөрөмж(компьютер)	155,825.8	165,738.5	9,912.7
Номын фонд	1,277.1	1,318.5	41.4
Программ хангамж	16,381.6	13,461.8	(2,919.7)
Тавилга, аж ахуйн эд хогшил	23,915.9	24,293.2	377.3
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	131.4	131.4	-
Бусад биет бус хөрөнгө	145,037.6	149,871.2	4,833.6
Бусад үндсэн хөрөнгө	13,860.9	12,608.6	(1,252.3)
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/	2,839.1	2,556.4	(282.8)
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/	13.9	6.7	(7.3)
Дүн	887,126.5	930,091.1	42,964.6

Эх сурвалж: ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 15,141.1 сая төгрөгийн, үнэ төлбөргүй болон хандив, тусламжаар 168.4 сая хөрөнгө бэлтгэж, балансаас баланст 43,549.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч нийт 58,858.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэн, 4,290.4

сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлж, 35.5 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, 11,568.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Дуусаагүй барилга, байгууламжийн дансанд 6,554.3 сая төгрөгийн 21 дуусаагүй хөрөнгө бүртгэлтэй байна. Тухайлбал:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2019 оноос эхлэн баригдаж байгаа Хууль сахиулах их сургуулийн спорт цогцолбор, номын сангийн барилгын ажлыг он дамжин гүйцэтгэж, тайлант хугацаанд 2,400.0 сая төгрөгийг дуусаагүй барилга байгууламжид хуримтлуулан бүртгэсэн,
- Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны барилгыг 2013 онд худалдан авч их засвар үйлчилгээ хийн дуусаагүй барилга дансанд бүртгэснийг барилга байгууламжийн дансанд шилжүүлэн бүртгээгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй /ХЗДХЯ 71.2 сая, Оюуны өмчийн газар 91.0 сая/,
- Урсгал зардлаас буюу багаж техник хэрэгслийн зардлаас хөрөнгийн зардалд зарцуулж, үндсэн хөрөнгө худалдан авсан /ХЗДХЯ 220.0 сая/,
- Санхүүгийн тайланд бүртгэлтэй суудлын авто машины гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлэн аваагүй /ХЗДХЯ/
- Үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ аваагүй /ЦЕГ-ын даргын 2019 оны А/253 дугаар тушаалаар Техник засварын төвөөс Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах 830 м2 талбайтай барилгыг балансаас балансад Санхүү, аж ахуйн албанд шилжүүлэн авсан боловч 1000.0 м2 газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй, ЦЕГ-ын Дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд бүртгэлтэй дараах барилга, объект, газрын хамт ашиглагдахгүй байгаагаас зарим барилга, объект нь ашиглах боломжгүй болсон, хөрөнгийг ашиглах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна. Тухайлбал: Төв аймгийн Лүн сумын 3 дугаар багийн нутагт байрлах /хуучнаар нохой сургалтын төвийн/ 12 ширхэг барилга, объект, 2 га газрын хамт, СХД-ийн 21 дүгээр хорооны нутагт Нарстай аманд байрлах "Оч" зуслангийн 11 ширхэг барилга, объект, 8.83 га газрын хамт ашиглагдаагүй, төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт байрлах Аварга тосонд байрлах 1000 м.кв амралт үйлчилгээний зориулалтаар баригдсан 3 ширхэг өвлийн байшин, газрын хамт 38.0 сая төгрөгөөр худалдан авсан байна/,
- Дотоод хэргийн их сургуульд Онцгой байдлын ерөнхий газрын 2016 оны А/15 дугаар тушаалаар нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах аврах 14 дүгээр ангиас гал унтраах тусгай зориулалтын автомашин бусад 4 нэр төрлийн 572,571.7 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хүлээлгэн өгсөн ч хөрөнгө шилжүүлэх шийдвэр байхгүй байна.

2.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 123,399.2 сая төгрөг болж өмнөх оноос 4,658.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан (-)
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	61,807.4	59,087.4	(2,720.0)
Богино хугацаат зээлийн өглөг	37.0	810.0	773.0
Ажилчидтай холбогдсон өглөг	34.8	567.3	532.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	55.1	20.0	(35.0)
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	350.4	108.6	(241.7)
Байгууллагад төлөх өглөг	1,773.4	16,158.6	14,385.2
Хувь хүмүүст төлөх өглөг	58,840.2	39,821.9	(19,018.3)
Татварын өглөг /ТӨҮГ/	284.9	516.8	231.8

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны өглөг /ТӨҮГ/	431.6	1,084.2	652.6
<i>Урьдчилж орсон орлого</i>	56,933.5	64,311.9	7,378.4
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	28,718.2	30,022.0	1,303.8
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	-	94.1	94.1
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	365.0	7,440.5	7,075.5
Бусад урьдчилж орсон орлого	27,662.2	26,752.2	(910.0)
Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар	188.2	3.2	(185.0)
Нийт дүн	118,740.8	123,399.2	4,658.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	109,470.1	115,369.9	5,899.8
ТӨҮГ	9,270.7	8,029.3	(1,241.4)
ДҮН	118,740.8	123,399.2	4,658.4

Эх сурвалж: ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн болон урьдчилж орсон орлогын дансны үлдэгдлийн 80.4 хувийг Банк хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албаны, 12.2 хувийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн төлбөр барагдуулах албаны шүүхийн шийдвэрийн дагуу байгууллага, хувь хүмүүст төлөх өглөг эзэлж байна.

2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 805,410.5 сая төгрөг байсан бол, эцсийн үлдэгдэл 886,402.2 сая төгрөг болж, 80,991.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Цэвэр хөрөнгө өмчийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	338,602.9	350,424.3	11,821.5
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	7,901.4	-	(7,901.4)
Өмнөх үеийн үр дүн	248,515.7	256,159.5	7,643.8
Тайлант үеийн үр дүн		66,256.7	66,256.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	210,390.5	213,561.7	3,171.3
Дүн	805,410.5	886,402.2	80,991.7

Эх сурвалж: ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал/Засгийн газрын сан дансны үлдэгдэл өссөн нь өмнөх онд үнэлэгдээгүй орхигдсон газрыг 4,638.0 сая төгрөгөөр үнэлсэн, төсөвт байгууллагуудын өмчийг ТӨҮГ-ын төрийн өмч дансанд зөрүүлэн бүртгэснийг аудитын явцад залруулсан нь голлон нөлөөлсөн байна.

Өмнөх үеийн үр дүн өссөн нь дахин үнэлгээтэй хөрөнгө хасагдсан, Банк хадгаламж, зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албанд борлуулахаар хүлээгдэж байсан барилгыг үндсэн хөрөнгөнд бүртгэснийг болон ХЗДХЯ өмнөх оноос хэрэгжиж эхэлсэн барилгын ажлын гүйцэтгэлийг Хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-аас авлага үүсгээгүй байсан зэргийг залруулсантай холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар баталсны дагуу тайлант онд 22,900.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж улсын төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэл 20,099.1 сая төгрөг буюу 87.8 хувьтай байна.

Хүснэгт №8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын бүртгэлийн ерөнхий газар	19,800.0	18,070.5	(1,729.5)	91.3
Цагдаагийн ерөнхий газар	3,100.0	2,028.6	(1,071.4)	65.4
Нийт дүн	22,900.0	20,099.1	(2,800.9)	87.8

Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлого 2,800.9 сая төгрөгөөр тасарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчлэлтэй холбоотой 23 үйлчилгээг цахимаар үнэ төлбөргүй үзүүлж эхэлсэн,
- Цагдаагийн ерөнхий газрын 2018 онд зарлагдсан жолооны үнэмлэхийн бэлдэц, хор дагалдах хэрэгсэл бэлтгэх тендер шалгаруулалтад гомдол гарч, энэ хугацаанд жолооны түр үнэмлэх олгож, 2019 онд түр үнэмлэхээ үнэ төлбөргүй сольсонтой холбоотой байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 13 хөтөлбөрт зориулан 538,362.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд 495,478.8 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 42,883.4 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Дампуурсан банк, хадгаламж зээлийн хоршоодтой холбоотой авлагыг бүрдүүлж, улсын төсөвт 20,600.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн ч гүйцэтгэл гараагүй байна.

Нийт зардлын 513,088.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 8,175.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээр, 17,099.3 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоор бүрдүүлж зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилтээс 512,639.1 сая, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 178,767.0 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 7,844.5 сая төгрөгийн нийт 699,250.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдэж, урсгал үйл ажиллагаанд 493,747.3 сая, хөрөнгийн зардалд 42,730.8 сая, нийт 536,478.0 сая төгрөгийг зарцуулж 162,772.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 536,478.0 мянган төгрөг буюу 1,884.2 сая төгрөгөөр дутуу зарцуулж, төсвийн гүйцэтгэл 99.7 хувьтай байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлээс материаллаг байдлаар дараах зардал хэмнэсэн байна. Үүнд:

- Бараа үйлчилгээний бусад зардал 808.1 сая төгрөгөөр /ШШГЕГ-ын харьяа байгууллагууд 414.0 сая төгрөгөөр, Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг 360.9 сая төгрөгөөр г.м/,
- Урсгал шилжүүлгийн зардал 438.7 сая төгрөгөөр /тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал ШШГЕГ 372.2 сая төгрөгөөр, Архивын ерөнхий газар 61.7 сая төгрөгөөр г.м/,
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 212.7 сая төгрөгөөр /ШШГЕГ 48.4 сая төгрөгөөр, ГИХГ 46.9 сая төгрөгөөр, ЦЕГ 12.1 сая төгрөгөөр г.м/,
- Хөрөнгийн зардал 152.6 сая төгрөгөөр /ХЗДХЯ 125.7 сая төгрөгөөр, ЦЕГ 11.8 сая төгрөгөөр, Мэдээлэл шуурхай удирдлагын төв 6.9 сая төгрөгөөр г.м/ тус тус хэмнэсэн байна.

Хөрөнгө оруулалтын 37 төсөл, арга хэмжээнд 42,883.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 42,736.8 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 1,552.5 сая, Засгийн газрын нөөц сан/Засаг даргын нөөц хөрөнгө/-аас 1,522.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 2,348.0, үндсэн үйл

ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 16,390.9 сая, нийт 21,813.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 6,285.6 сая, эд хогшил урсгал засварын зардалд 3,620.4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 3,506.4 сая, цалингийн зардалд 2,436.1 сая, хөрөнгийн зардалд 1,793.7 сая, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 1,258.6 сая, нормативт зардалд 1,126.6 сая, бусад зардалд 1,408.3 сая нийт 21,435.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 377.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 6 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, 217 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 147 байгууллагын санхүүгийн тайлан аудитад хамрагдаж, 23 байгууллагад итгэл үзүүлж, 53 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 47,800.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 28,355.4 сая төгрөгийн алдааг залруулж, 88.5 сая төгрөгийн 35 төлбөрийн акт тогтоож, 5,309.8 сая төгрөгийн 69 албан шаардлага хүргүүлж, 14,046.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 263 зөвлөмж өглөө.

А.Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 13,224.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 8,143.9 сая төгрөгийн алдааг залруулж, 5,081.0 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өглөө.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Тухайлбал:

- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд ХЗДХЯ болон Хөрөнгө оруулалт барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь хөрөнгө оруулалтын ажлыг тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс хоорондын тооцоо үүсгэж бүртгээгүй;
- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд Архивын ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн засгийн газрын оруулсан капитал дансыг "Төрийн өмч /ТӨҮГ/" дансанд тайлагнасан;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд харьяа байгууллагуудын Төрийн сангийн дансанд төвлөрсөн орлогыг тооцоо нийлж баталгаажуулан, дансны үлдэгдлийн баталгааг үнэн зөв хийгээгүй төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд орлого дутуу тайлагнасан /АЕГ 16.0 сая, Шүүхийн шинжилгээний хүрээлэн 1.5 сая, ЦЕГ 5.5 сая/.

Төсвийн ерөнхийлөн захирагчид 5,081.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгснийг менежментийн захидлаар хүргүүлсэн болно.

Б.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 6 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нэгтгэгдсэнээс ШШГЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 3,030.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,300.9 сая төгрөгийн алдааг залруулж, 661.5 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал авсан 3 байгууллагын албан тушаалтанд хариуцлага тооцуулах дүгнэлт хүргүүлж, 1,067.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 23 зөвлөмж өглөө.

В.Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчдын нийт 217 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 141 байгууллага аудитад хамрагдаж, 23 байгууллагад итгэл үзүүлж, 53 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 133 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 8 байгууллагын /ГИХГ-ын баруун бүс дэх газар, Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн хэлтэс, Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар, Говьсүмбэр аймгийн ШША, ХХЕГ-ын харьяа 0118-р анги, ШШГЕГ төвлөрсөн хангамж, Хэрэмт цамхаг УТҮГ, Баганууртоосго ТӨААТҮГазар/ санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 31,545.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 18,910.6 сая төгрөгийн алдааг залруулж, 88.5 сая төгрөгийн зөрчилд 35 төлбөрийн акт тогтоож, 4,648.3 сая төгрөгийн зөрчилд 61 албан шаардлага хүргүүлж, 7,897.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 234 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Салбарын чиг үүргийн болон санхүүгийн үйл ажиллагааг үр нөлөөтэй төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, дотоод хяналтыг сайжруулахад дараах асуудлуудад Төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс анхаарлаа хандуулж шийдвэрлэх шаардлагатай байна. Тухайлбал:

1. Харьяа байгууллагууд арилжааны банканд зохих зөвшөөрөлгүйгээр, зориулалт тодорхойгүй данс нээн орлого төвлөрүүлж байгаа нь Төсвийн тухай хууль, Сангийн сайдын баталсан заавар журам зөрчигдөж, төсвийн хөрөнгийг дотоод хяналтгүй, зориулалт бусаар зарцуулах эрсдэл үүссэн байна. Тухайлбал:
 - Оюуны өмчийн газар зохих зөвшөөрөлгүйгээр Голомт банканд 1175116159 тоот данс нээн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 194.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 129.6 сая төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлж, 65.0 сая төгрөгийг давсан орлого зарцуулах зөвшөөрөл авч ХЗДХЯ-д шилжүүлсэн;
 - ШШГЕГ нь Төрийн банканд 102100699262 тоот данс нээн харьяа төрийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого, өмнөх оноос дамжиж ирсэн санхүүжилт зэрэг нийт 6,353.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 3,929.3 сая төгрөгийг зарцуулсан;
 - Гадаадын иргэн харьяатын газрын Баруун бүс дэх газар арилжааны банканд данс нээлгэж акталсан автомашины дуудлага худалдааны дэнчингийн орлого, дуудлага худалдааны төлбөрийн 8.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэн төвлөрүүлсэн.
2. Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны санхүүгийн тайлангийн дампуурсан банк, хадгаламж, зээлийн хоршоодоос авлагыг барагдуулж, хувь хүмүүст төлөхөөр бүртгэсэн 27,683.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг шийдвэр гүйцэтгэгч нартай анхан шатны баримтыг үндэслэн тооцоо нийлж баталгаажуулах ажил хангалтгүй байна. Энэ нь цаашид төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд материаллаг хэмжээгээр нөлөөлөх эрсдэлтэй байна.
3. Харьяа байгууллагуудад ахмадын сан байгуулж, төсөвт тусгалгүйгээр зарлагын хэмнэлтээс шилжүүлэн зарцуулж байгаа нь МУЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3-т “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэж заасантай

зөрчилдөж байна. Салбарын хэмжээнд ахмадын сангийн зориулалттай 15 данс / Төрийн сангийн дансанд 13, арилжааны банкинд 2 данс/-д 230.2 сая төгрөгийн мөнгөн үлдэгдэл байршиж байна.

Дараагийн аудитаар авч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

1. Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 356 дугаар тогтоолын дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны хуучин конторын барилга, барилгын өмчлөх эрх, газар эзэмших эрхийг Монголбанканд шилжүүлэх ажлын хэрэгжилт, шинээр баригдсан нэгдсэн конторын барилгын санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэлийг Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн аудитаар хянаж үзэх шаардлагатай байна.
2. Засгийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн “Э-Тайлан”-ийн системд төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ санхүүгийн үр дүнгийн тайланд “үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол” зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртгөөс салган тайлагнаж байна. Энэ нь Сангийн сайдын баталсан 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-тай тус тус нийцэхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 56 төрлийн 20895 мэдээллийг олон нийтэд мэдээлэхээс 20060 мэдээллийг хугацаанд нь, 835 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн 2 зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай байна. Тодруулбал:

- “Хууль зүйн системийн байгууллагуудын үйл ажиллагаа, бүртгэл, тайлагналын онцлогийн талаар баримтлах арга зүйг боловсруулан батлуулж, нэгдсэн журмаар мөрдүүлэх” зөвлөмжийн дагуу судалгаа, шинжилгээний ажлыг хийгдэж байгаа бөгөөд хэрэгжилт 70 хувьтай байна.
- “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийн төлөвлөлтийг бодит тоон мэдээлэлд үндэслэн үнэн зөв төлөвлөх” зөвлөмжийн дагуу эдийн засгийн ангиллыг буруу бүртгэж тайлагнах, батлагдсан төсөвт зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулах, төсвийг зориулалт бусаар зарцуулах зэрэг алдаа, зөрчил буурсан ч орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтаа хэрэгжүүлээгүй бөгөөд хэрэгжилт 50 хувьтай байна.

ХЗДХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, бүрэн хэрэгжүүлснээр дүгнэсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС, АОУС, түүнд нийцүүлэн гаргасан Санхүүгийн тайлангийн аудитын журам, заавар, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 19,444.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 20,196.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгч байна.

Зөрчилгүй дүгнэлт

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим чиглэгдсэн.

Энэ нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан асуудлууд нь цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Хууль зүй, дотоод хэргийн яамны салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт 2014 оноос өнөөг хүртэл өөрчлөлт, шинэчлэлт хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн бодлого алдагдах, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, ижил төрлийн ажил гүйлгээг өөрөөр бүртгэж, тайлагнах зэрэг эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Салбарын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, мөрдөх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын дүнг асуудлын бүртгэлээр танилцуулав.

3.2 Дотоод хяналттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Дотоод хяналт хангалтгүй, холбогдох хууль, тогтоомж, журам, зааврыг мөрдөж ажиллаагүйгээс шалтгаалж Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний

байгууллагуудын төсвийн төвлөрүүлэн болон төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 34,575.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 20,211.5 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулж, 88.5 сая төгрөгийн 35 төлбөрийн акт тогтоож, 5,309.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 69 албан шаардлага хүргүүлж, 8,965.4 сая төгрөгийн зөрчилд 257 зөвлөмж өгсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль, журам, дүрэм зөрчигдөж, харьяа төсвийн захирагчдын санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй илэрхийлэгдэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад анхааран дотоод хяналтыг сайжруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын дүнг асуудлын бүртгэлээр танилцуулав.

3.3. Үндсэн хөрөнгийн хөдлөлтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

ХЗДХЯ-ны санхүүгийн тайланд бүртгэлтэй конторын 1605.8 м² талбайтай, 876.3 сая төгрөгийн өртөг бүхий барилга, барилгын өмчлөх эрх, 524м² газар эзэмших эрхийг Монголбанканд шилжүүлэх Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 356 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасаа, шилжүүлэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь ТӨБЗГ-ын шийдвэрт зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, санхүүгийн тайланд хөдлөл өөрчлөлтийг тусгана" гэж заасантай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Төсвийн тухай хууль, холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах,

3.3.3 Өгсөн зөвлөмж:

ХЗДХЯ-ны конторын хуучин барилгыг үнэлэх, шилжүүлэх, данс бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулж, уг зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын дүнг асуудлын бүртгэлээр танилцуулав.

3.4 Орлогын төлөвлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Тайлант онд ШШГЕГ арилжааны банканд данс нээн харьяа байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд бий болсон 4,908.2 сая төгрөгийн, Оюуны өмчийн газар үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 42.2 сая төгрөгийн нийт 4,950.4 сая төгрөгийн давсан орлогыг зохих зөвшөөрөлгүйгээр зарцуулсан байна.

Мөн Оюуны өмчийн газрын давсан орлогоос 65.0 сая төгрөгийг ХЗДХЯ-д шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 35 дугаар зүйлийн 35.2-т "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна", 35.3-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ", 46.2-т "Энэ хуулийн 46.1-д заасан төсвийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан журмын Сангийн сайдын 2019 оны 74 дугаар тушаалаар баталсан журмын 1.5-д "Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг бусад төсөвт байгууллагад шилжүүлэн зарцуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд бий болох орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавиагүйгээс батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулах, зориулалт бусаар зарцуулах эрсдэлтэй байна.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд бүрдэх орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, давсан болон нэмэлт орлогыг зохих журмын дагуу зарцуулж байгаа эсэхэд зохих хяналтыг тавьж байх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын дүнг асуудлын бүртгэлээр танилцуулав.

